

V. ДЭЛХИЙ ДАХИНЫ ТҮҮХЭНД ХОЛБОГДОХ АСУУДАЛ

ГЛОБАЛЬЧЛАЛЫН ТҮҮХЭН ҮЙЛ ЯВЦ

М.Мөнхзул. Хөдөө аж ахуйн их сургууль

Өгүүллийн товч утга: Глобальчлал хэмээх үйл явц нь хэдийгээр XX зууны сүүл үеэс яригдаж эхэлсэн боловч хүн төрөлхтөн түүхэн явцдаа глобальчлах, интеграцчлах ямар нэгэн оролдлого хийсээр ирсэн билээ. тухайлбал, Македоны Александрын байлдан дагуулалт, Чингисийн байлдан дагуулалт, бүх арьстныг эзэлж Ари үндэстэнийг дэлхийд ноёрхуулах гэсэн Гитлерийн бодлого, социалист интеграци, өнөөгийн мэдээлэл технологийн эрин үе бүгд глобальчлах үйл явц мөн билээ. Глобальчлал гэдэг бол зах зээлийн төлөөх тэмцэл юм гэдгийг түүх нотолсоор ирсэн билээ.

Түлхүүр үг: глобальчлал, антиглобальчлал, санхүүгийн сүйрэл, олон туйлт, потенциал, валлот, колоничлол, хэсэгчилсэн глобальчлал, лакаль глобальчлал, элит улс, нэг туйлт, үнэлэмжийн загвар.

Бодит глобальчлал. Глобальчлал гэдэг ойлголт нь хоёр өөр маягаар ойлгогддог учраас түүний тодорхойлолтууд хоорондоо маргаантай байдаг. Глобальчлалын эхний тодорхойлолт нь - бодит глобальчлал юм. Бодит глобальчлал гэдэг нь дэлхийн бүх орнуудад барууны эдийн засаг, улс төр, соёл, технологи ба мэдээллийн кодыг өнөөдөр бодитоор хэрэгжүүлж буй нэг талаас хүчээр тулгах явдал юм. Энэхүү глобальчлалыг “баян хойд зүг” (НАТО гийн орнууд), “алтан тэрбум” хэрэгжүүлдэг энэ нь тэдний дэлхийн ноёрхлыг баталгаажуулахад чиглэгдсэн юм. Энэ нь колончлолын шинэ хэлбэр бөгөөд “баян” нь “ядуугаа”, “хөгжилтэй нь” “хөгжилгүйгээ” удирддаг юм. Улс орнууд энэ тохиолдолд өөрийн тусгаар тогтнолоо алдаж уг глобальчлалын системд шингэж ордог эсвэл “гологдол орон” болох болно. Энэхүү глобальчлал нь либерал эдийн засаг, радикал монетаризм, үнэт цаасны бирж, венчурын аж ахуйн нэгж гэх мэт зүйлийг хөгжүүлэхэд чиглэсэн зүйлд анхаарлаа төвлөрүүлдэг. Улс төрийн хувьд уг глобальчлал нь либерал-ардчилсан бүтэц, “хүний эрх” гэдэг үзэл суртлын давамгайлал, “нээлттэй нийгэм” нийтэд тогтоох шаардлагатай байгааг илэрхийлдэг. Төрт байдал бага багаар алга болж, янз бүрийн их гүрний захиргааны систем нь үгүй болдог. Стратегийн хувьд энэхүү глобальчлал нь АНУ Цэргийн хүчний болон түүний хамтрагчид нийт гаригийг шууд хянахыг хэлж байгаа юм. Энэхүү глобальчлалыг “дэлхийн глобальчлал”, “нэг туйлт” буюу өөрөөр хэлбэл хүйтэн дайнд ялалт байгуулсан өөрийн давуу байдлаа хадгалж чадсан орчин үеийн Барууны үзэл бодлыг илэрхийлсэн глобальчлал гэж нэрлэж болно. Уг глобальчлалын үйл явцад баримталж буй олон улсын эрх зүйн модель болох- НҮБ, НАТО гэх мэтийн бүтцүүд алга болж цаашид “глобальчлалын элитүүдийн” гарт эдийн засаг, улс төр ба цэргийн захирах бүх эрх нь төвлөрсөн шинэ бүтэц бий болно. Дэлхийн эдийн засгийн бүтэц нь олон орны хүчний чадавхи дээр үндэслэсэн өнөөгийн оршиж буй олон улсын бүтцээс давамгайлсан байдлаа илүү илэрхийлж байгаагаараа ялгаатай юм. АНУ-гийн стратегчид дэлхийн бүтцийг Америкийн улс төр эдийн засгийн ба соёлын моделүүдийг гаригийн бүх орон зайнд шилжүүлсэн байдлаар үзэж байгаа юм. Энэхүү санаа нь “Дэлхийн Нэгдсэн улс” гэдэг концепцийн суурь нь болсон юм.

Олон туйлт глобальчлал. Энэхүү глобальчлал нь цэвэр онолын төвшинд байдаг ба хөгжингүй орнуудын хүмүүнлэгийн салбарт их тархсан байдаг юм. Хүмүүнлэгийн глобальчлал гэдэг бол хоёр туйлуудын зөрчил арилсны дараах соёл ба иргэншил хоорондын харилцан хөгжиж байгааг хэлж байгаа юм. Энэ утгаараа уг “глобальчлал” нь бусад улсуудад Барууны нэгдсэн эдийн засаг, соёл, улс төр, мэдээлэл, үнэлэмжийн моделийг хүчээр тулгах бус харин “дэлхийн хэмжээний туршлага солилцох, янз бүрийн субьектудын хоорондын харилцан яриа гэж үздэг. Уг глобальчлал нь “колончлолын”

хандлагыг үгүй хийж түүхэн ба соёлын замналыг сонгох бүрэн хэмжээний эрх чөлөөг янз бүрийн улсуудад олгоход чиглэгдэнэ. Энэ глобальчлал нь олон төрлийн нийгэм- улс төр, эдийн засгийн системуудыг зөвшөөрдөг ба дайны эсрэг шинжтэй байдаг бөгөөд АНУ-ыг ч оруулан бүх орнуудыг цөмийн зэвсгээ хураах эсвэл бие биенээ хязгаарласан цөмийн хэд хэдэн туйл бий болгохыг хүлээн зөвшөөрч байгаа юм.

Уг глобальчлалыг олон туйлт глобальчлал гэж нэрлэж болох ба энэхүү глобальчлалын өөр нэг төрөл бол “хэсэгчилсэн глобальчлал”, “локаль глобальчлал” буюу “том орон зайны глобальчлал” гэж хэлж болно. Дээрх байдал нь соёл иргэншлийн хувьд нэг кодтой орнуудыг эдийн засаг, улс төр ба нийгмийн харьцааны хувьд ойртохыг харуулж байгаа юм. Энэ глобальчлал нь гаригийн хэмжээнд бус харин нэг соёл иргэншлийн хүрээнд явагдаж байдаг үйл явц юм. Энэхүү “бүсчилсэн глобальчлал”-ын жишээ бол өнөөгийн Европын Холбоог нэрлэж болно. “Олон туйлт глобальчлал” бол хүмүүнлэгийн сэхээтнүүдэн төсөл бөгөөд “нэг туйлт” глобальчлал амжилттай хэрэгжих нөхцөлд ашиггүй байдалд орох орнуудын сонирхолыг илэрхийлж буй цэвэр онолын загвар юм. Олон туйлт глобальчлал нь (өөрөөр хэлбэл одоо байхгүй боловч байж болох байсан глобальчлал) бодит глобальчлалын (өөрөөр хэлбэл одоо байгаа боловч байхгүй байж болох байсан глобальчлал) альтернатив глобальчлал мөн. Энэхүү хоёр өөр утга санаа илэрхийлж буй глобальчлал нь өөрийн үндсэн параметраараа зөрүүтэй байхаас гадна өөрийн үндсэн зарчмаараа эсрэг үзэл санаатай юм.

Антиглобализм. Антиглобальчлал бол глобальчлалын үйл явцын эерэг агуулга ба зайлшгүй болон бодит байдлыг үгүйсгэж байгаа үзэл санааны систем юм. Антиглобальчлал нь юуны өмнө “бодит глобальчлал”, “нэг туйлт глобальчлал”, “америк төвтэй глобальчлалын” эсрэг чиглэгдэж, либерал эдийн засгийн давуу байдал – “ядуу Өрнөд” орнуудад явуулж буй Барууны (АНУ) неоколончлолын бодлого болон барууны (америкийн) үнэлэмжийн систем бусад системүүдээс давуу байдалтай байгааг сануулж байдаг. Өөрөөр хэлбэл, техникийг ёс суртахуунаас, бие хүнийг нийгмээс, баян чинээлэг байдлыг ядуурлаас дээгүүр үзэж, тойрон хүрээлж буй орчинг “технологийн дэвшилт”-ээс доогуур үзэж буйг эсэргүүцэж байгаа бөгөөд, социал-демократ, консерватив мөн бусад улс төрийн системууд орших бүрэн эрхтэй гэж үздэг.

Үүнээс үзэхэд антиглобальчлал нь эхний утга санааг агуулж буй глобальчлалын үйл явцын сөрөг байр суурийг бүрэн хэмжээгээр илэрхийлдэг ба харин “хоёр дахь глобальчлал”, “олон туйлт”, “хүмүүнлэгийн” гэж нэрлэгдэж буй глобальчлалтай харилцан нийцэх боломжтой юм.

ГЛОБАЛЬЧЛАЛЫН НЭГДҮГЭЭР ҮЕ ШАТ

VI-XV зуун

ӨМНӨД БА ХОЙД ЕВРОПЫН ЭДИЙН ЗАСГИЙН НЭГДЭЛ.

Эртний грек-римын соёл иргэншлийн задрал, Баруун ба Зүүн Ромын хуваагдсаны дараа Европын ихэнх хэсэг нь Атиллагийн удирдлагын доор Хүннүүгийн дайралтанд өртөн сүйрсэн юм. Зөнч Мухаммедын уриалгаар Арабийн тарж бутарсан омгууд нэгдэж нэг үндэстэн бий болгож зөнчийг нас барсны 100 жилийн дараа Энэтхэгийн хил хязгаараас Ойрхи Дорнод, Хойд Африкаас Испани хүртэл өөрийн агуу их гүрнийг байгуулсан юм.

VII зуунаас арабуудын дарамтын улмаас зуун ба өрнөд славянчууд эртний худалдааны замаар Польш, Балтын орон, Дон, Днестр, Ижил ба бусад мөрөнгүүдийн усны сангаар Хойд зүг рүү ихээр нүүх болсон. Европын тарж бутарсан орнууд яваандаа арабчуудын эсрэг нэгдэж Агуу Карлын гүрэн бий болсон юм. Тэр нь Пуатьегийн тулалдаанд Европ руу дайрч байсан арабчуудыг зогсоосон Карл Мартеллын ач хүү нь байжээ. Европын зээлийн үйл ажиллагаанд Италийн эртний санхүү Венеци ба Генуя төвүүд давуу байдалтай байжээ. Агуу Карлын импери нь арабчуудын империтэй идэвхтэй харилцаж Европ Дорнотын хоорондын солилцоог холбож байсан. Өмнөд Европын эртний

эдийн засаг болон Дорнодын худалдаа өөрийн үйл ажиллагаандаа Хойд зүгийг татан оролцуулахад зайлшгүй хүргэсэн юм.

IX зуунд норманчуудын нөлөө хүчирхэг болсны улмаас Европыг Хойд Өмнөд хоёрын хооронд байнгын цэргийн сөргөөлдөөний үе рүү оруулсан юм. Агуу Карлын үе дэх сэргээлт нь эргээд зогсонги байдалд орж Дорнод Ром-Византийн нөлөөний улмаас худалдааны замууд нь арай аюул багатай Ижил, Дон, Днепр мөрөнгүүдийн усан сан дараа нь Балтийн тэнгис рүү чиглэгдсэн юм. Дээрх үйл явцын уршгаар Европын аюултай замаас хол эртний худалдааны замд 11-12-р зуунд засгийн эрхийн төлөөх дотоод тэмцлийн улмаас задарсан Киевын Орос улс бий болсон юм.

XIV зууны дунд яг ийм шалтгаанаар Арабын гүрэн задарч түүний оронд түрэмгий Османы гүрэн гарч иржээ. Хар болон Дунд газрын тэнгисийн бүсэд туркчууд худалдааг зогсоосны улмаас Венецийн санхүү хямралд хүргэжээ. Генуя хотын худалдаачид болон банкирууд Испани ба Португалийн туслалцаатайгаар Зүүн зүгтэй худалдаа хийх далайн гарц хайж эхлэв. Иймд XV ба XVI зуунд Васко Да Гамын экспедиц нь Малайзийн эхүүн амтлагчийг захирах харин Христофор Колумб нь Испанийн хувьд хязгааргүй Америкийг ноёлох боломж олгожээ. Молуккийн олтригоос халуун ногоо ба эхүүн амтлагч Хойд зүгийн зах зээлд орж ирснээр Европын санхүү ба худалдааны төв нь 1501 оноос Антверпен болсон юм. Энэ үед Латин Америкт колонийг өргөжүүлж буй Испанийн гол зээлдэгч болох Генуя хотын болон Антверпены худалдааг санхүүжилж буй өмнөд германы банкны эзэд хүчирхэг болсон юм.

ГЛОБАЛЬЧЛАЛЫН ХОЁРДУГААР ҮЕ ШАТ

1501-1557 онууд

АУГАА НЭЭЛТЭЭС ИСПАНИЙН ДАМПУУРАЛ ХҮРТЭЛ.

Колони өргөтгөх тусам Испанийн өр нэмэгдэж байжээ. Испанийн I Карл нэгдсэн католик Европыг байгуулах талаар мөрөөддөг байсан. Яг энэ үед Генуя ба Венецийн хооронд дорнод дахины эхүүн амтлагчийг худалдаалах хөрөнгийн өрсөлдөөн явагдаж байсан.

Мөн энэ үед Мексикт мөнгөний уурхайг нээснээр энэ нь Испанийн мөнгийг оруулах гарцыг нээж үүгээрээ европын мөнгөн мөнгийг үнэгүйдэлд хүргэж “Мөнгөний их сүйрэл” бий болсон. Энэ хямралд зоосон мөнгө хийхэд шаардлагатай мөнгөгүй байсан Англи улс хамгийн их хэлмэгдсэн. Англид Ромын засаг захиргааны эсрэг “шашны бодлого” боловсруулж эхэлсэн ба түүний үр дүнд хойд европын протестантууд хүчирхэг болж Испанийн католик засаг захиргаа ба эзэнт улс сүйрэлд хүржээ. Яг энэ үед хаан 4-р Иван Грозный Европтой дипломат харилцаа тогтоох үйл ажиллагаа эхлэв. Москвагийн Орос нь өөрийн хил хязгаараа өмнө зүг рүү тэлж Сибирийг өөрийн эрхшээлдээ оруулах үйл ажиллагаа эхлүүлэв. 1557 онд “Мөнгөний их сүйрэл”-ийн дараа Испанийн дампуурал болсон.

ГЛОБАЛЬЧЛАЛЫН ГУРАВДУГААР ҮЕ ШАТ

1557-1618 онууд

ЭНЭ ҮЕИЙГ “ГЕНУЯЧУУДЫН ЗУУН” ГЭЖ НЭРЛЭДЭГ.

Испанийн дампуурал нь бүх Европын санхүүг сүйрэлд хүргэсэн. Англид фунтын хямрал болсон байна. Энэхүү фунтын ханшийн өөрчлөлт нь үйлдвэрлэлийг гүн хямралд оруулсан. Энэ хатуу нөхцөлд Англи нь Европоос 100 жилээр өмнө аж үйлдвэрийн хувьсгалын үед орсон. Орос улс нь Польш ба Шведтэй Балтийн тэнгисийн худалдааны замд гарц олохын төлөө байлдаж байсан. Европт мөнгөн зоосны өртгийн уналт нь Францын алтан ливрийн эрэлтийг нэмэгдүүлсэн. Ливрийг дэвэргэсэн өсөлт нь худалдааны балансын хомсдолд хүргэж дотоодын шашны удаан үргэлжилсэн дайны нөхцөлд Францын өрийг нэмэгдүүлсэн.

XVI зууны II хагас гэдэг нь Английн Газар дундын ба Хар тэнгист худалдаагаа түрэмгийлэн тэлж байсан үе. Португал нь Испанийн засаг захиргаанд шилжсэнээр

Испанийн өрийн өсөлтийг дахин бий болгосон. Нидерланд нь өөрийн тусгаар тогтнолоо Испаниас тусгаарласан. Англи, Испанийн хоорондын худалдааны өрсөлдөөн нь тэднийг дайтахад хүргэж Испанийн усан цэргийн флотыг устгаснаар Англи бүх тэнгист өөрийн ноёрхлоо тогтоосон. XVII зууны эхэнд фунтын тогтсон үнийг хадгалснаар Английн санхүүг хойд зүгт бүрэн хэмжээгээр хямралд хүргэжээ. Испанийн өрнөөс хамааран зэсэн зоос гаргах шаардлага гаржээ. Уг хямрал нь эзэнт улсыг бүхлээр нь хамарчээ. Энэ үед Европын капитал нь инфляциас зугатааж Өмнө ба Дорно зүгийн хоорондын далайн худалдааны гол агент нь болсон Голланд руу гарч, Амстердам нь Европын санхүү ба худалдааны төв болжээ.

1618 онд санхүүгийн хямрал нь Германы үндэсний ариун ромын эзэнт улсад протестант ба католикуудын хооронд шашны мөргөлдөөнд хүргэж үүгээрээ 30 жилийн дайны эхлэлийг тавьжээ. Энэ үе нь Ришелье ба XIV Людовикийн үйл ажиллагаатай холбоотой. Энэ үйл ажиллагааны зорилго нь Испанийг сулруулах ба Европын худалдааны хамгийн гол судас болох Рейн хүртэл Францын хил хязгаарыг тэлэхтэй холбоотой юм. Гэхдээ энэ дайнд чухал үүргийг европын санхүүгийн төв болсон Голландын капитал ба дипломат үйл ажиллагааг гүйцэтгэсэн. 30 жилийн дайны үр дүнд Вестфалийн энх тайван тогтжээ. Герман нь биеэ даасан 300 жижиг засаг захиргаанд хуваагдаж XVIII зуунаас өмнө бүрэн уналтанд орсон.

Харин Швеци нь Хойд ба Балтийн тэнгист худалдаанд бүрэн хэмжээгээр хяналт тавих эрхийг авчээ. Хаан ба “удаан” хэмээх парламентын хоорондын иргэний дайнд суларсан Англи нь санхүүгийн хямралд 30 жилийн дайнаас ангид үлдсэн. 30 жилийн дайны үр дүнд Голланд нь Европын ерөнхий зээлдэгчийн хувьд өөрийн байр сууриа бататгаж харин Франц нь өөрийн хамгийн аюултай дайсан болох Габсбургийн эзэнт улсыг ялагдалд хүргэжээ.

ГЛОБАЛЬЧЛАЛЫН ДӨРӨВДҮГЭЭР ҮЕ ШАТ

1648-1701 онууд

ЭНЭ ҮЕД ГОЛЛАНДЫН КАПИТАЛ БА ФРАНЦЫН БОДЛОГО ИХ ХЭМЖЭЭНИЙ НӨЛӨӨТЭЙ БАЙСАН

Энэ үе шат нь Францын абсютизмын цэцэглэлт ба уналттай холбоотой. 30 жилийн дайн нь Габсбургийн ялагдлын дараа XIV Людовикийн Франц нь өөрийн хил хязгаараа тэлэх бодлогод шилжиж энэ нь Европ дахь сонирхлын тогтсон балансыг хөндөж байсан ба Европын бүх хүчний дахин байр сууриа эзлэх үйл ажиллагаа явагдаж байжээ.

1648-1661 онуудад Голландад капитал ба Английн аж үйлдвэрийн шугамын дагуу дайны дараах харилцаа бүрэлдэж энэ нь Вильгельма III Оранскийн захиргааны доор Англи Голланд хоёр нэгдсэнээр төгсжээ. Үүний үр дүнд өрийн шинэ өсөлт ба санхүүгийн хямрал болсон.

1661-1700 онууд XIV Людовикийн 3 дайн ба Францын эсрэг Голланд тогтмол холбоо бүрэлдүүлж байжээ. 1670-аад онуудад Туркийн талаас байнга өсөж байсан заналхийллийн үр дүнд Оросын оролцоотойгоор Европын холбоо байгуулагджээ. Европын дипломат үйл ажиллагаа Оросыг хүчирхэг болгохгүй байх зорилгоор Турктэй байнга мөргөлдүүлж байжээ.

XVII зууны сүүлд Голландын капиталууд Францыг тусгаарлах зорилгоор бүслэх үйл ажиллагаа дуусгажээ. Франц Английн хоорондох олон удаагийн удаан хугацааны дайнууд XVIII зууны бүх түүхийг дүүргэсэн. Дээрх дайны улмаас Европт инфляци бий болж санхүүгийн задрал болсон байна. Европын эрэлт буурснаар Голландын колоничлолын худалдаанд өрийн пирамидийг өсгөхөд хүргэсэн.

Испанийн өв залгамжлалын төлөө Голландын холбоотой хийсэн 4 дэх дайн нь Францыг дампууралд хүргэсэн.

Өмнө зүгт Орос Туркийн дайны үр дүнд Орос нь Хар ба Газар дундын тэнгист гарцтай болов. Турктэй байгуулсан энх тайван нь Оросыг өөрийн бодлогоо хойд зүгт

Балтийн тэнгист гарцын төлөө тэмцэлд чиглүүлэх боломжийг өгөв. 1701 онд орос Шведид дайн зарлав. Уг дайн нь түүхэнд Хойд дайн хэмээх нэрээр орсон байдаг. Энэ үеэс Их Пёторын эрин эхэлсэн юм.

ГЛОБАЛЬЧЛАЛЫН ТАВДУГААР ҮЕ ШАТ

1700-1795 онууд

Цаасан мөнгөний эмиссийн сүйрлийн дараа мөн Испанийн өв залгамжлалын төлөө хийсэн дайны дараа Франц удаан хугацааны эдийн засгийн хямралын үед орсон. Инфляци, худалдааны алдагдал, капиталын шилжилт ба хүмүүсийн ядуурал нь хаант засгийн хямрал ба Францын хувьсгалд хүргэж энэ нь Наполеон Бонапартын ганцаарчилсан ноёрхлоор дууссан.

Францын хувьсгал, Наполеоны дайнууд Европын орнуудын төлбөрийн чадварыг зогсонги байдалд оруулсан. Борлуулалтын зах зээлийн хямрал нь Европын бүх орноос зээл авч байсан агуу том Голландын Ост-Индийн компаний худалдааг уналтанд хүргэсэн. Үүний улмаас Голландын худалдааны капитал нь XVIII зууны сүүлээр өөрийн сонирхлоор Английн аж үйлдвэр лүү чиглүүлэв. Энэ үеэс Лондонгийн банкнуудын 200 жилийн турш ноёрхлыг тогтоосон. Гэвч капиталын илүүдэл нь зөвхөн инфляцийг өсгөөд зогсохгүй татварыг нэмэгдүүлснээр колонид эсэргүүцэл бий болсон. Энэ үйл явцад XVIII зууны сүүлд удаан хугацааны тэмцлийн дараа АНУ Англиас тусгаарлан тусгаар тогтнолоо тогтоосон.

ГЛОБАЛЬЧЛАЛЫН ЗУРГААДУГААР ҮЕ ШАТ

1795-1914 онууд

XIX зууны эхэнд наполеоны дайнууд, Английн эх газрын бүслэлт ба Англи, Франци, Оросын цэргийн хомсдлын өсөлттэй холбоотой юм. Энэ үе нь Ротшильдын банкны байшин бий болж нөлөө нь өсөж эхэлсэн. Наполеон Ватерлогийн тулалдаанд ялагдсанаар Ротшильдын байшин Английн засгийн газрын үнэт цаасыг ашиглаж хуурамч үйл ажиллагаа явуулснаар Английн өрийг бүрэн хэмжээгээр хянах бололцоотой болсон юм. Хуучин Ертөнцийн / Старый Свет/ эдийн засаг ба улс төрийн хямрал нь АНУ Европын хооронд дахь улс төрийн орон зайг улам холдуулахад хүргэсэн юм. Латин Америк нь чөлөөт хөдөлгөөнөө эхэлж, Европоос хөндийрч өрийн чиглэлээ АНУ руу хандуулсан юм. Оросод хямралыг даван туулах зорилгоор мөнгөний системийг тогтворжуулах талаар арга хэмжээ авав. XIX зууны дундаас эхлэн Англид либерал эдийн засгийн өрчлөн байгуулалт ба аж үйлдвэрийн өндөр өсөлт эхэлжээ.

• Англид болон Европод нилээн ширүүн боловч богино хугацааны эдийн засгийн ба аж үйлдвэрийн өсөлт үе эхэлсэн юм. Дэлхийн эдийн засгийг английн экспортын үндсэн дээр либералчлах үйл ажиллагаа явуулж байжээ. Харин зөвхөн АНУ өөрийн зах зээлээ европын инфляцаас хамгаалах арга хэмжээ авчээ.

Английн Ротшильдын капиталын давамгайлалыг дэлхийд буй өрсөлдөгчдийг дарамтлах байдлаар тогтоож байжээ. Оросын эдийн засгийн өсөлтийг Крымийн дайн зогсонги байдал оруулж үүний үр дүнд рубль суларч Орос улс өөрийн хомсдолыг Европоос зээл авч нөхөхөд хүргэв. АНУ-ийн эдийн засгийн өсөлт мөн Хойд Өмнөд хоёрын хоорондын Иргэний дайнаас шалтгаалан зогссон боловч АНУ Европоос зээл авахаас татгалзав.

Европт энэ жилүүдэд хөдөлмөр капитал хоёрын хоорондын зөрчил нэмэгдсэнээр хувьсгалын хүлээлтийн байдал өсөв.

Наполеоны дайны дараах Европод цэргийн хомсдол ба удаан хугацааны зогсонги байдал нь Хуучин ертөнцийн эдийн засгийг төлбөрийн чадваргүйдэлд хүргэсэн юм. Алдагдал нь зардлыг нэмэгдүүлж байв. Зардлаас хамааран үнийн калькуляци өсөж инфляцийг багасгахад бэлэн бус мөнгөний масс шаардлагатай байсан ба араас нь мөн бэлэн мөнгөний шаардлага ихээр гарч түүний дутмаг байдлаас хамааран эмисс хийх хэрэгтэй байв. Эмиссийн хувиарлалт нь нийгэм ба газар зүйн хувьд тэгш бус байсан. Иймд

илүүдэл капиталтай нь фритрейдинг буюу чөлөөт худалдаа хийх талаар санал гаргаж байв. Харин худалдаа нь зардлыг багасгахыг шаарддаг. Үүний үр дүнд Суэцийн каналыг барих хөрөнгө оруулалтын том төсөл бий болов.

Энэ жилүүд дэлхийн хямралаар дүүрэн байсан ба хөрөнгийн биржийн заах зээл сүйрч байсан юм. Европ АНУ хоёр их хэмжээний дампуурал, хүнд уналтаар дүүрэн байсан энэ үед зээлдэгч зээлдүүлэгч нарын дунд дэлхийн капиталыг байрлуулах хөрөнгийн эрх дахин хувиарлах үйл ажиллагаа зэрэгцэн явагдаж байсан юм.

1875 онд АНУ алтан стандарт руу шилжин орсноор банкны ба аж үйлдвэрийн капиталын хуримтлуулах үе эхлэв.

Германд улс төрийн эв нэгдэл, санхүүгийн системийн төвлөрөл, гаалийн нэгдсэн орон зай байгуулагдсан үе юм. Орос удаан хугацаагаар үргэлжилсэн санхүүгийн хямралд орж санхүүгийн өөрчлөн байгуулалт гадаад өрийг шилжүүлэлт явагдаж байсан боловч шинээр бий болсон санхүүгийн хямрал нь үр дүнгийн нь үгүй хийжээ.

Их гүрний капитал нь инфляци ба эрсдэлээс өөр тийшээ зугатааж байгаа нь эзэнт улсын түрэмгийлсэн колоничлолын бодлого болон түүний эсрэг үндэсний эрх чөлөөний төлөө хөдөлгөөнийг бүрэлдүүлжээ.

1914 онд Европ нь дэлхийн колоничлолын тэмцэлд ялагдал хүлээсэн ба зөрчил нэмэгдэж энэ нь дэлхийн I дайнд хүргэсэн.

ГЛОБАЛЬЧЛАЛЫН ДОЛДУГААР ҮЕ ШАТ

1914-1945 онууд

Дэлхийн I дайн эхэлснээр АНУ Германтай байлдаж буй холбоотнуудын хомсдлын үндсэн зээлдэгч болсон. Дайны жилүүдэд долларын мөнгөн масс нь 2 дахин нэмэгджээ. Бүх захиалга нь АНУ-ын үйлдвэрлэлд хийгдэж харин холбоотнууд барааны зээлийг авч өр нь өсөж байсан. Дайны үр дүнд Версалийн энх тайвны гэрээний нөхцлийн дагуу дайтаж байсан орнууд бүгд АНУ-д өртэй болсон.

Герман нь өрийн ачааллыг даагаагүйгээс 1920 онуудад инфляцийн хүү нь жилийн 40 мянгад хүрсэн. Нийгмийн улс төрийн тогтворжилтын үндэс болсон дундаж анги устгагдсан ба үүний үр уршгаар Германы үндсэрхэг үзэл нэмэгдсэн. Д.М.Кейнс нь Версалийн энх тайвны гэрээг хүмүүнлэг бус гэж нэрлэжээ. Ийм энх тайван шинэ дайныг гарахад хүргэнэ гэж хэлсэн байна. 1929 онд германы банк өрийн үйлчилгээ ба төлөлтийг зогсоосныг зарлаж энэ нь Германыг дампуурсны илэрхийлэл байв.

Үүний дараа нийт Европын хямрал эхэлж долларын зээлийн их хэмжээний масс нь Европоос эргээд АНУ руу чиглэгджээ. АНУ-д мөнгөний илүүдэл нь инфляцийг бий болгож үүний дараа 1930-аад онуудын Их хямрал болжээ. 1930-аад оны сүүлд олон улсын улс төр ба эдийн засгийн харьцаа нь зогсонги байдалд орж үүний үр уршгаар Дэлхийн II дайн эхэлсэн.

ГЛОБАЛЬЧЛАЛЫН НАЙМДУГААР ҮЕ ШАТ

Дэлхийн II дайны дараа

1944 онд Бреттон Вудсед болсон олон улсын бага хурал дээр дэлхийн II дайны дараах үеийн олон улсын санхүүгийн харилцааны шинэ системийг тогтоожээ. Олон улсын валютын сан ба Дэлхийн банк нь түүний институт болсон. Энэ систем нь Америкийн долларыг дэлхийн үндсэн зээлдэгч болно гэж тогтоосон бөгөөд гэвч тэр нь бусад орны валютын хувьд өөрийн өртгөө өөрчлөхгүй байх ёстой. Энэ нь дайны дараах Европ ба Японыг сэргээн босоход боломж олгосон.

Баруун Герман нь өөрийн эдийн засгаа хамгийн эхэлж сэргээн босгож эхэлсэн. Түүний өөрчлөн байгуулалт нь зах зээлийн аж ахуй эдийн засгийн төрийн зохицуулалттай хосолж байсан. Энэ өөрчлөн байгуулалт нь хүн амын дундаж анги ба эдийн засагт тогтвортой төлбөрийн эрэлтийг бий болгоход чиглэгдсэн.

Эдийг засгийг сэргээн босгох цаг хугацааны явц нь Германыг Их гүрний тоонд эргүүлэн оруулах шаардлагаас урган гарсан. 1948 оны зуны валютын өөрчлөн

байгуулалтын эхлэл нь уг оны II хагаст аж үйлдвэрлэлийн өсөлт нь 50 хувь хүрчээ. Харин 1951 онд 1936 оныхоос өөрөөр хэлбэл үйлдвэрлэлийн дайны өмнөх түвшин нь 30 хувиар өсчээ. Өөрчлөн байгуулалтын 5 дахь жилдээ Герман нь аж үйлдвэрийн төрийн секторыг хувьчилж эхэлсэн байна. Төсвийн байдал нь үйлдвэр зарах шаардлагагүй болгожээ.

Япон бусад орны ижил өөрчлөн байгуулалт хийсэн. Аж үйлдвэрийн томоохон төвүүд нь 2 атомын бөмбөгөнд өртсөн өөрийн эрчим хүчний нөөцгүй өр өгөөжтэй газрын хомсдолтой орон 15 жилийн өөрчлөн байгуулалтын дараа 1960-аад оны эхэнд өөрийн хөрөнгөөрөө Америкийн санхүү ба үнэт цаасны зах зээлд нөлөө үзүүлж эхэлсэн.

Энэ хугацаанд ЗХУ дайчилсан эдийн засгийн нөхцөлд дайны дараах сэргээн босголтыг дуусгасан. 1964 оноос эхлэн гадаад дотоодын өр Европ ба Японы капитал болон экспортын дарамтнаас шалтгаалан АНУ нь ганцаарчилсан нөхцлөөр Бреттон Вудсийн тогтсон ханшийн тухай хэлэлцээрээс татгалзсан. 1971 онд АНУ-ын ерөнхийлөгч Р.Никсоны шийдвэрээр долларыг алтаар солихыг больжээ.

Энэ үеэс эхлэн дэлхий ертөнц нь бүх нийтийн итгэл болсон доллар мөн АНУ-ын цэргийн хүч дээр худалдан авах чадвар нь тулгуурласан цаасан мөнгөөр зээлийн үйл ажиллагаа явагддаг болжээ.

1992 оноос социалист системийн задралын дараа постсоциалист орон зайнд зарим орнуудын өөрчлөн байгуулалтын үе эхэлжээ. Өөрчлөн байгуулалтын үр дүн нь нэлээд ойролцоо бөгөөд зөвхөн тооны үзүүлэлтээр ялгаатай. Дундаж анги ба төлбөрийн эрэлт нь устгагдсан. Үндсэн хөрөнгийн нийт хуримтлалын өрсөлдөх түвшний тухай асуудал болон үндэсний валютын хөрөнгө оруулалтын үүргийг сэргээх талаарх асуудал тавигдаж байгаагүй юм. Их хэмжээний өрнөөс хамааран санхүүгийн системүүд нь зээлдэгч нарын хатуу улс төрийн нөхцлийн дарамтанд оржээ. Нийгэм ба гадаадын зээлдэгч нараас аж үйлдвэрийн капиталын өртгийн бууралттай холбоотой дотоодын өрийн хэсгийн өсөлтийг нууцалж байв. Шинэ бүтээгдэхүүн нь үйлдвэрлэлийн өмнөх үе шатнаас олсон орлого үнэгүйдэхээс удаан бүтээгддэг байжээ. Статистикийн үзүүлж байгаагаар үйлдвэрлэлийн хэмжээний өсөлт болон эдийн засгийн санхүүгийн үр дүн нь 5 дахин хурдацтай буурч байгаа аж. Уг үзэгдлийг “хөрвөх чадварын хөшилт” гэж нэрлэдэг бөгөөд энэ үзэгдлийн тухай ямар нэгэн мэдээлэл пост зөвлөлтийн орон зайны эдийн засгийн шинжлэх ухааны салбарт байдаггүй юм. Зээлдэгчийн хөрөнгийн хөрвөх чадварыг бууруулж буй эдийн засагт гадаад болон дотоод хөрөнгө оруулалт хийгддэггүй.

Дүгнэлт

• Дээрхээс үзэхэд глобальчлал хэмээх үйл явц нь өөртөө эерэг болон сөрөг үр дагаварыг улс орнуудын эдийн засаг болон улс төрийн амьдралд учруулж байгаа нь илэрхий байна. Мөн энэ үйл явцын тэргүүлэгч нь үргэлж тухайн түүхэн явц дахь хамгийн хүчирхэг улс нь байдаг ба ядуу буурай улсын хувьд тийм ч таатай нөхцөл байж чаддаггүй юм байна. Ер нь аливаа улс орны өнө мөнхийн сонирхол нь эдийн засгийн чадамжаа сайжруулах байдаг учраас глобальчлалаар хаацайлсан засаглалын төлөөх тэмцэл түүхэн үеийн туршид явагдсаар иржээ. Хэдийгээр уг үйл явц нь дэлхийн улс орнуудыг нэгтгэх үйл явц байж болох талтай ч дайн тулааныг ч мөн дагуулсаар иржээ. Энэ нь аливаа үндэстэнд мөнхийн түнш гэж байдаггүй, харин мөнхийн эрх ашиг байдаг гэсэн үгийг сануулж байна.

Резюме

На основании вышеуказанного можно сказать, что процесс, называемый глобализацией, оказывает и позитивные и негативные влияния на экономическую и политическую сферы общественной жизни. Во главе процесса глобализации стоит самая могущественная страна в мире, что конечно, не может позитивно отражаться на

слаборазвитых странах. Так как для любой страны повышение экономического потенциала является приоритетом, то можно сказать, что в течение всей истории, пользуясь глобализацией, между ними в латентной форме ведётся борьба за власть. Хотя процесс глобализации ведёт, с одной стороны, к объединению, но с другой стороны он сопровождается и воинами, что ещё раз доказывает правоту того, что “нет вечных партнёров, а есть вечные интересы”.

Ном зүй

1. Мартин.Г.П., Х.Шуман “Западная глобализация”
2. Панарин.А.С., “Искушение глобализмом”
3. Уткин.А.И., “Мировой порядок XIX века”
3. Цыганков.П.А., “Теория международных отношений”
4. Майкл Д.Интригейтор, “Глобализация как источник международных конфликтов и обострения конкуренции”, Международный журнал – Проблемы теории и практики управления
5. В.П.Колесова и М.Н.Осьмовой, “Мировая экономика зарубежных стран”
6. Шлихтер.С.Б., Лебедева.С.Л., “Мировая экономика”